

**БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЕСДҮГЭЭР САРЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**


2025.09.26

Баян-Өндөр сум

№	Зохион байгуулагдах арга хэмжээ	Хэрэгжилтийн тайлан	Хамрагдсан хүний тоо	Зарцуулсан төсөв		Даргь тушаа (дугаа)
				Улсын төсөв	Орон Нутгийн төсөв	
1	Шри-Чинмой бүх нийтийн гүйлтийн арга хэмжээ	Шри Чинмойн нэрэмжит "Өөрийгөө ялах-Эрдэнэт марафон 2025" бүх нийтийн гүйлтийн арга хэмжээ 2025 оны 09 дүгээр сарын 13-нд А.Амарын талбайгаас заагдсан маршрутын дагуу 4 км, 21 км зайд эрэгтэй, эмэгтэй ангиллаар амжилттай зохион байгуулагдаж 7 насны ангилалд 100 гаруй тамирчин оролцлоо. Арга хэмжээг аймгийн ЗДТГ, БТСГ, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Хангарьд спорт цогцолбор, Шри Чинмойн марафоны багийн хамт хамтран зохион байгуулсан.	100	-	-	-
2	Ерөнхий боловсролын сургуулиудын сарагчдын Намрын спартакиадыг зохион байгуулахад хамтран ажиллах	Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын 2025-2026 оны хичээлийн жилийн Намрын спартакиадын арга хэмжээ 09 дүгээр сард Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд хуваарийн дагуу зохион байгуулагдлаа. Өнөөдрийн байдлаар 8 сургуулийн 5400 сурагчид кросс гүйлт, байрнаас уртад харайлт, 100 метрийн гүйлтийн төрлөөр өрсөлдөж сургуулиудын аваргуудаа тодрууллаа.	5400	-	-	-
3	Монголын Бүх ард түмний XVI наадмын шигшээ тэмцээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын төрлүүдэд тамирчдыг баг бэлтгэн	Монголын Бүх ард түмний XVI наадмын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын наадам 2025 оны 09 дүгээр сарын 15-20-ны өдрүүдэд Улаанбаатар хот, Налайх дүүрэгт зохион байгуулагдаж манай аймгаас спортын 7 төрөлд 58 тамирчин оролцлоо. Тус тэмцээнээс манай тамирчид: •Тусгай бочи-4 дүгээр байр •Тусгай хөнгөн атлетик- 1 алт, 2 мөнгө, 1 хүрэл багийн нийлбэр 3-р байр •Пара хөнгөн атлетик- 2 мөнгө, 1 хүрэл •Хонхтой бөмбөг - 1 алт, 1 мөнгө багийн нийлбэр дүнгээр 1-р байр	57	-	ОНТ	

	оролцуулах, тайлан мэдээг хүлээн авч нэгтгэх	•Суугаа волейбол- 1 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн. Тус тэмцээнд аймгийн Суугаа волейболын "Бид чадна" холбоо, Монголын Хараагүйчүүдийн холбооны Орхон аймгийн салбар хороо, ХБХ-ийн Эцэг, эхийн холбоон тэргүүн нар баг тамирчдаа амжилттай бэлтгэн оролцууллаа.				
4	Архизын улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд ажил үүргийн хуваарийн дагуу ажиллах	Улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд мэргэжилтэнгүүд хариуцсан чиг үүрэг, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан бичгүүдийг архивт нэгтгэн цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.	5	-	-	-
5	А, Б заалны цэвэрлэгээ үйлчилгээ, заалны шал будах засварын ажил болон бусад ажилд ажил үүргийн хуваарийн дагуу оролцох	Байгууллагын 2025 оны төлөвлөгөөний хүрээнд А, Б заалны тоос буулгах, цэвэрлэгээ болон заалны шал будах, шугам тавих ажил хийгдэж мэргэжилтэнгүүд ажил үүргийн хуваарийн дагуу тухай бүр ажилласан. Мэргэжилтэн Б.Гансайхан Эрдэнэ багийн 20-р сургуулийн хажууд баригдах БТСГ-ын зориулалттай заал, машины зогсоол барих зөвшөөрлийн гарын үсгийг Эрдэнэт ус, ЭБЦТС, ЭДЦС, Байгаль орчны газар, МХС, ОБГ дарга, Ерөнхий архитектор, инженерүүдээр зургуулж хүлээлгэж өгсөн.	4	-	-	-

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.ОДГЭРЭЛ